

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн
78 дугаар тогтоолын 30 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Нэгжийн нэр:

Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар

Албан тушаалын нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авах гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулж зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал боловсруулах;
2. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
3. Сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
4. Сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагаанд дотоод аudit хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, Засгийн газарт хүргүүлэх;	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгжийн даргаар хянуулан, албажуулж, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	Т, Г
	2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, Засгийн газарт хүргүүлэх;	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгжийн даргаар хянуулан, албажуулж, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	Т, Г
	3. Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, Засгийн газарт хүргүүлэх;	Хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.	Т, Г
	4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгжийн	Т, Г



	шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, Засгийн газарт хүргүүлэх;	даргаар хянуулан, албажуулж, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	
	5.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал боловсруулах.	Санал боловсруулж мэргэжил арга зүйгээр хангасан байна.	T, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусlamжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; 2.Концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.	X, Г X, Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгууллага, зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; 2.Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх Нэгжийн даргаар хянуулан, албажуулж, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудит хийх; 2.Дүгнэлт, зөвлөмж боловсруулж эрсдэлийн удирдлагаар хангах.	Дотоод аудит хийгдсэн байна. Дотоод аудит хийгдэж, дүгнэлт, зөвлөмж гарсан байна.	T, X T, X
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг мөрдөж ажилласан байна.	Г

	<p>2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</p>	<p>Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна.</p>	Г
	<p>3.Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх.</p>	<p>Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлсэн байна.</p>	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.						
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Эдийн засаг /0311/; - бизнес ба удирдахуй /0411, 041201-041203, 041301-041303/; - эрх зүй /042101, 042103/; - математик, статистик /054102, 054105, 054201/. 						
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх; 						
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Төрийн албанад 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанад 3-аас доошгүй жил ажилласан байх. 						
Ур чадвар	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="text-align: center; width: 30%;"> Дүн шинжилгээ хийх </td><td> <ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх. </td></tr> <tr> <td style="text-align: center;"> Асуудал шийдвэрлэх </td><td> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах. </td></tr> <tr> <td style="text-align: center;"> Багаар ажиллах </td><td> <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; </td></tr> </table>	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх. 	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах. 	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх. 						
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах. 						
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; 						

		- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	- гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар; - кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ


Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын дарга.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн байгууллага, холбогдох албан тушаалтан; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; - Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, гадаадын иргэн, хуулийн этгээд; - Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд.
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
---	--

Албан тушаал:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА


ТУ32861 6806236 9022010236
2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:
Дугаар: **078**
11192824071
ТУ31614 8 91289551

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: **2025. 03 . 24**

Дугаар: **A/80**

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

2025 оны ... дугаар сарын ... -ны өдөр

(И.БАТХҮҮ)

